



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

БАТАЛСАН АЛБАН ТУШААЛТНЫ
ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ,
ТАЙЛАН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ТӨМӨРДУЛАМ

Э.ДАВААХАТАН

М.ГАЧМАА

АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	3
1.1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.....	4
1.2. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт.....	5
1.3. Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	7
ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	10
2.1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт.....	10
2.2.1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт.....	12
2.2.2. Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.....	12
2.3. Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт.....	25
2.4. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд настай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт	26
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	27
3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт	27
3.2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт.....	40
3.3. Архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн шийдвэрлэлт	44
3.4. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт, түүнд тавих хяналт.....	46
3.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал.....	47
3.6. Шүүх хяналтын байгууллагад төлөөлөл хэрэгжүүлж ажилласан талаар.....	47
3.7. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	48
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	50
4.1. Хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа.....	51
4.2. Хүний нөөцийн ил тод байдал.....	51
4.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал	52
ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ	52
5.1. Холбогдох чиг үүргийн дагуу Нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээ.....	52
5.2. Байгууллагын дотоод хяналт, шалгалт хийсэн тухай мэдээлэл.....	54
5.3. Бусад цаг үеийн шинжтэй олон нийтийн ажлын талаар.....	55
ЗУРГАА. ДҮГНЭЛТ	60

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Хотын стандарт, хяналтын газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтууд болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, төрийн хяналт шалгалтын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Алсын хараа Нийслэл хотын хөгжлийг чиглүүлэх хотын стандартын тогтолцоог хөгжүүлнэ.

Эрхэм зорилго Хотын стандартын тогтолцоог хөгжүүлж хотын засаглал, бүтээн байгуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээнд дэлхийн жишигт хүрсэн чанарыг нэвтрүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамж, 2023 оны “Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/304 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц, орон тоог 8 хэлтэс, 108 албан хаагчтай байхаар шинэчлэн баталж, жилийн эцсийн байдлаар 62 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас шилжин ирсэн 11 хяналтын чиг үүрэг бүхий 37 улсын байцаагчдыг Барилга, Дэд бүтцийн хяналтын чиглэлээр 2 хэлтэс болгон зохион байгуулалт хийж, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа тасралтгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн. Газрын бүтэц чиг үүрэгт төрийн хяналтын чиг үүрэг нэмэлтээр тусгагдаж Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/174 дүгээр захирамжаар газрын дүрмээ шинэчлэн батлуулж үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллаж байна.



НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” баримт бичигт тус газрын хариуцан хэрэгжүүлэх 4 зорилтын 5 арга хэмжээг байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар 88%-ийн хэрэгжилттэй Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. Үүнээс зарим арга хэмжээг товч дурдвал:

ЗААЛТ 5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар зөвлөмж, арга зүйгээр хангах, хамтран ажиллах:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд нутгийн захиргааны нийт 20 байгууллагын дэд ажлын хэсэгт тус газрын 7 албан хаагчид ажиллаж, Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд арга зүйгээр ханган ажиллаж байна.

ЗААЛТ 9.5.2 Ногоон барилгын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх:

Барилга, байгууламжаас ялгараах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй пассив, ногоон барилгын төлөвлөлтийг нэвтрүүлэх зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны суурь судалгаа хийсэн. Судалгаанд үндэслэн “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд тавигдах шаардлага” хотын стандартын төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчээр “Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв” НҮТББ-тай гэрээ байгуулсан.

Амины орон сууцны төлөвлөлт, барилгын хийц төрлөөс хамааруулан сонгох боломжтой 6 төрлийн жишиг зураг төсөл боловсруулж байна. Зураг төсөлд эрчим хүчний аудитораар баталгаажуулалт хийгдэх ба ингэснээр иргэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны санхүүжүүлэх ногоон зээлд хамрагдах боломж бүрдэнэ.



Зураг 2. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишигээ зураг

Хотын стандартын төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагаас санал авч тусган 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 20 дугаар хурлаар танилцуулсан. 2024 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулахаар бэлтгэл арга хэмжээг ханган ажиллаж байна.

1.2. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтооолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тус газрын чиг үүргийн хүрээнд үндсэн хэрэгжүүлэх 1, хамтран хэрэгжүүлэх 8 буюу нийт 9 арга хэмжээ тусгагдсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар 85.5%-ийн хэрэгжилттэй Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. Үүнээс зарим арга хэмжээг товч дурдвал:

ЗААЛТ 5.1.2.1. Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна:

Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны 02-13-04/023/03 дугаартай “Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй хүүхдийн тоглоомын талбайд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандартын хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийг тодорхойлж, зөрчлийг арилгуулах зорилгоор 2023 оны 3-5 дугаар сард 9 дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны барилга, хотхон болон гэр хорооллын гудамжинд байрлах нийт 474 хүүхдийн тоглоомын талбайг хамруулж, хяналт шалгалт зохион байгуулсан.



Зураг 3. Хяналт шалгалтаар илэрч буй зөрчлүүд



Шалгалтаар хүүхдийн тоглоомын талбайг насны ангиллаар төрөлжүүлж тохижуулаагүй, ногоон байгууламжгүй, тоног төхөөрөмжүүд эвдрэл гэмтэл ихтэй, стандартын дагуу аюулгүй байдлыг хангуулаагүй, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийдэггүй зэрэг нийтлэг зөрчил илэрч, эзэмшигч, ашиглагч байгууллагуудад стандартын хэрэгжилтийг хангуулах, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр улсын байцаагчийн зөвлөмж, шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

ЗААЛТ 6.1.5.2. Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлнэ:


Нийслэлийн хэмжээнд орон сууц болон олон нийтийн барилгын гадна орчин, дотоод орон зай, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэйгээр төлөвлөхөд дагаж мөрдөгдөх “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц” бүлэгт хамаарах 2 хотын стандартыг боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлуулсан.



UCS 1001A:2023
“Хөгжлийн бэрхшээлтэй
иргэдэд дэд бүтцийн
хүртээмжийг дээшлүүлэх
арга зүйн удирдамж”



UCS 1001C:2023
“Хөгжлийн бэрхшээлтэй
иргэдэд хүртээмжтэй дэд
бүтцийн зураг төсөл”



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж байна. 2023 онд төрийн болон нийгмийн үйлчилгээний 43 барилгыг “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны үндсэн шаардлага” MNS 6055:2009 болон холбогдох барилгын норм дүрэм, хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангуулах үүрэг даалгавар өгч, ашиглалтад оруулсан.

1.3. Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тус газрын хариуцан хэрэгжүүлэх 6, хамтран хэрэгжүүлэх 3, нийт 9 арга хэмжээ тусгагдсан. 2023 оны жилийн эцэст 83.3%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, биелэлтийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP-Хяналт шинжилгээ үнэлгээ системээр тайлгагнасан.

ЗААЛТ 5.3.6 Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ:

Бодлогын баримт бичигт тусгагдсан дараах 4 хотын стандартын төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. Зөвлөлийн гишүүдээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу хянан тохиолдуулах ажлын хэсэг байгуулж, 2024 оны 1-р улиралд багтаан Зөвлөлийн хуралдаанд эргэн танилцуулахаар шийдвэрлэв.

Хүснэгт 1. Хотын стандартын төслийд

Д/д	Хотын стандартын нэр	Боловсруулсан байгууллага	Санал өгсөн байгууллагууд
1	“Нийслэлийн үндны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага”	“Эс И Си” ХХК	НБОГ, УСУГ
2	“Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага”	“Хаан ус тэнгис” ХХК	
3	“Хот доторх оршуулгын газрын орчны эрүүл аюулгүй байдлын ерөнхий шаардлага”	“Архидеа” ХХК	УБЗАА, НОБГ, Буяны зан үйлийн холбоо ТББ.
4	“Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх гарын авлага”	“Инженер геодези” ХХК	НБОГ, НМХГ.

Хотын стандартын төсөлд иргэд, олон нийтээс санал авахаар байгууллагын <https://standard.ub.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан.

ЗААЛТ 5.1.22 Хотын стандартыг боловсруулах, батлуулах үйл ажиллагааны журмын төсөл боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж хэлэлцүүлэх:


Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, мөрдүүлэх зорилтын хүрээнд “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төслийг 2023 оны эхний хагас жилд боловсруулсан. Журмын төсөлд иргэд олон нийтээс ирүүлсэн 712 дэмжсэн санал, нийслэлийн нутгийн захиргааны 34 байгууллагаас ирүүлсэн 41 тухайлсан саналыг тусгаж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 15, 20 дугаар хуралдаанд танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.

Хурлаас өгсөн санал, үүргийн дагуу журмын төсөлд нэмэлт засвар хийн, “Хотын стандарт боловсруулах аргазүйн заавар” баримт бичгийг шинэчлэн боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар ажиллаж байна.

ЗААЛТ 5.1.24. Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууцны барилгыг ашиглалтад оруулах захиалгчийн хүсэлтийг судлах:


Нийслэлийн хэмжээнд нийт 23 байршилд 53 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлж байгаагаас 39 нь үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, 14 нь тодорхой шалтгааны улмаас цуцлагдсан бөгөөд гэр хорооллын газрыг дахин барилгажуулах үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж, 3 байгууллагын төсөл хэрэгжүүлэгчийг цуцлуулах санал зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн тус төслийн хүрээнд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 247 өргөдөл гомдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулсан.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийг батлагдсан зураг төслийн дагуу зохион байгуулах талаар Хот байгуулалт, хөгжлийн газарт мэдэгдэл хүргүүлж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хийсэн хяналт шалгалтаар илэрч буй зөрчил дутагдал, цаашид холбогдох журмуудыг шинэчлэх шаардлагатай байгаа талаар санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригт 2023 оны 01/1478 дугаартай албан бичиг хүргүүлэв.



Зураг 4. Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт хэрэгжсэн төслийн байршил

Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 24 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 2856 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан.





Зураг 5. Төслийн хүрээнд баригдсан орон сууцны барилгууд

ЗААЛТ 6.1.27 Нийслэлийн авто зам, тээврийн салбарт мэрдүүлэх хотын стандартыг боловсруулж батлуулах:

Монгол улсад авто тээвэр, замын байгууламжийн салбарт 240 орчим хууль, норм ба дүрэм, стандарт мөрдөгдөж байна. Нийслэлийн хэмжээнд авто зам, замын байгууламжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, авто замын тэмдэг тэмдэглэгээ, замын байгууламжийн чанарыг боловсронгуй болгох зорилгоор “Авто зам, замын байгууламж” бүлэгт хамаарах дараах 2 хотын стандартын төсөл боловсруулав. Үүнд:

1. “Хотын авто зам төсөллөх ерөнхий шаардлага” хотын стандарт,
 2. “Авто замын засвар, арчлалтад тавигдах ерөнхий шаардлага” хотын стандарт.





UCSB:2023

“Авто замын засвар,
арчлалтад тавигдах ерөнхий
шаардлага”

Дээрх хотын стандартын төслүүдэд холбогдох 5 байгууллагаас нийт 24 санал ирүүлсэн бөгөөд тухайлсан 17 саналыг тусгасан. Төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. 2024 онд багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Байгууллагын хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалаар сар, улирал бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж ажилласан.

Газрын чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын 6 хуулийн 25 заалт, Их Хурлын 1 тогтоолын 2 заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Монгол Улсын Засгийн газрын 13 тогтоолын 22 заалт, Монгол Улсын Засгийн газрын 9 хуралдааны тэмдэглэлийн 11 заалт, Монгол Улсын Засгийн газар болон Ерөнхий сайдын албан даалгавар 3, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж 1, нийт 36 хууль, тогтоол, шийдвэрийн 67 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангулан ажиллав.

Хяналтад авсан 67 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 96 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Агуулга		Бүгд	Монгол Улсын хууль	Монгол Улсын Их Хурлын тогтоол	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарпиг	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Монгол Улсын Засгийн Газрын албан даалгавар
Үүнээс:									
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		36	6	1	3	13	1	9	3
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		67	25	2	3	22	1	11	3
Үүнээс	Биелсэн 90-100	64	18	2	3	22	1	11	3
	Хэрэгжих шатанд								
	70								
	30								
	Хугацаа болоогүй								
Тасарсан									
Биелэлтийн дүн /хувь/		96	99.2	90	100	97.7	90	96.3	100

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 хуралдааны тэмдэглэлийн 4 заалт, Нийслэлийн Засаг даргын 10 захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны 4 тэмдэглэлийн 5 заалт, нийт 22 захирамжлалын баримт бичгийн 26 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хүснэгтээр үзүүлбэл:

Агуулга		Бүгд	НИТХ-ын тогтоол	НИТХ-ын хуралдааны тэмдэглэл	Нийслэлийн Засаг даргын захирамж	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны
Үүнээс:						
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		22	7	1	10	4
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		26	7	4	10	5
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн	100	15	-	4	8
	Хэрэгжих шатанд	70	11	7	-	2
	Хэрэгжилт хангалтгүй	30	-	-	-	-
	Хэрэгжээгүй	0	-	-	-	-
	Хугацаа болоогүй		-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/		93.3	90	90	94	88

Байгууллага хамтран болон дангаараа хяналтад авагдсан нийт 22 тогтоол шийдвэрийн 26 заалтаас бүрэн хэрэгжсэн 15 заалт, хэрэгжих шатандаа 11 заалт, нийт дээд газрын тогтоол шийдвэрийн дундаж биелэлт 93.3%-ын хэрэгжилттэй байна.


1.2.1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, нийслэлийн хэмжээнд 2008-2023 оны хооронд баригдсан нийт 1739 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, холбогдох мэдээллийг нэгтгэж Цахим хөгжил, харилцаа холбооны яамд хүргүүлж, <https://shilen.gov.mn/> сайтад ил тод нээлттэй байршуулсан. Үүнд:

- Нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагаас 2009-2012 онд ажилласан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 1011 дүгнэлтийг холбогдох мэдээллийг Архивын ерөнхий газраас;
- Хотын стандарт, хяналтын газраас хариуцаж эхэлсэн хугацаа буюу 2020 оны 08 дугаар сараас эхлэн 2023 оны хооронд ашиглалтад орсон 728 барилгын мэдээллийг байгууллагын цахим архив, мэдээллийн сангаас тус тус шүүж нэгтгэв.

1.2.2. Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт: 2023 онд батлагдсан нийт 66 захирамжийн хүрээнд газрын үндсэн үйл ажиллагаанд холбоотой заалтын хэрэгжилтийг ханган ажиллав. Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд 5 захирамж батлуулж, дээд газрын тогтоол шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан нийт 41 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан байна.



Газрын хариуцан хэрэгжүүлэх захирамжийн заалтуудын биелэлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан.

Хүснэгт 2. НЗД-аар батлуулсан захирамжууд

№	Батлагдсан огноо	Дугаар	Захирамжийн нэр	Товч утга
1	2023.03.06	A/174	Дүрэм шинэчлэн батлах тухай	Тус газарт төрийн хяналтын үндсэн чиг үүрэг нэмэгдсэнтэй холбогдуулан газрын дурмийг шинэчлэн баталсан. Улмаар газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн A/16 дугаар тушаалаар газрын нийт 8 хэлтсийн үйл ажиллагааны дурмийг шинэчлэн батлав.
2	2023.03.16	A/242	Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” удирдамж, 4 бүлэг 126 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөө батлагдсан.
3	2023.03.27	A/288	Ажлын хэсэг байгуулах тухай	Нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилгын ажил гүйцэтгэж байгаа 55 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж дүгнэлт гарган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.
4	2023.03.30	A/304	Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/1649 дүгээр захирамжийн зарим заалтад өөрчлөлт оруулж тус газрын орон тоог 108 хүнтэй байхаар шинэчлэн баталсан.
5	2023.07.18	A/815	Ажлын хэсэг байгуулах тухай	Бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтын хүрээнд “Ногоон бүс”-д хамруулах “Үйлчилгээний чанар, стандартыг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал” боловсруулсан.


Нийслэлийн Засаг даргын захирамжийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг дурдвал:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны A/170 дугаар захирамжийн хэрэгжилт: “Барилгын чанар, аюулгүй байдал, стандарт” зөвлөгөөний бэлтгэлийг хангах, зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Зөвлөгөөн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдаж, тус газраас дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд:

- Зөвлөгөөнд оролцогчдод урилга хүргүүлж, урьдчилсан болон ирцийн бүртгэл хөтлөн нийт 70 гаруй байгууллагын 220 гаруй төлөөлөл оролцсон.
- Зөвлөгөөний үеэр газрын дарга С.Төмөрдүлам “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа ба чанар, аюулгүй байдал” сэдвээр

барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар илтгэл танилцуулсан.

- Барилга чанар, аюулгүй байдалтай холбоотой танилцуулга мэдээлэл хүргэж, 12 төрлийн хотын стандартыг сурталчлан танилцуулж ажиллалаа.



Зураг 6. "Барилгын чанар, аюулгүй байдал, стандарт" зөвлөгөөний үеэр 2023.03.21

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай" 194 дүгээр захирамжийн хэрэгжилт: "Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд дараах 3 дэд ажлын хэсгүүдэд томилогдож, шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Хүснэгт 3. Ажлын хэсэгт хүргүүлсэн мэдээлэл

№	Дэд ажлын хэсэг	Мэдээлэл	Байгууллагын нэр
1	Газар хөдлөлтийн гамшигийн үеийн дуурайлган үзүүлэх дадлага, сургууль зохион байгуулах хээрийн эмнэлэг дэлгэх	Багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгаа, хүн хүчиний судалгаа	НОК
2	Нүүн шилжих дадлага сургуулийг зохион байгуулах	Ажлын төлөвлөгөөнд санал тусгав.	УБЗАА
3	Дэд бүтэц, барилга байгууламжийн судалгаа хийх	2020 оны 08 сараас 2023 оны 03 сарын 23-ны өдрийг хүртэл ашиглалтад оруулсан барилгын мэдээлэл	ХБХГ

Команд штабын сургуулийг зохион байгуулах ажлын хүрээнд газрын даргын 2023 оны А/31 дүгээр тушаалаар Газар хөдлөлт болон гамшигийн үеийн бэлэн байдлыг хангуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах түр штаб, мэргэжлийн багийн ажиллах удирдамж, хуваарь гарган 2023 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд байгууллагын хэмжээнд амжилттай зохион байгуулсан.

Түр штабыг 24 цагаар 3 ээлжээр тогтмол ажиллуулж, 11 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн багийг хамгаалах нэг бүрийн хувцас, бэлэн байдлын цүнх, шаардлагатай багаж хэрэгслээр хангуулан штабын үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр илтгэж ажиллалаа.



Зураг 7. Команд штабын бэлтгэл сургуулилтын үеэр

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хэрэгжилт: Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд газрын даргын 2023 оны А/12 дугаар тушаалаар хууль, норм дүрэм стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн байгуулсан. Төлөвлөгөөний төсөлд нийслэлийн нутгийн захиргааны нийт 45 байгууллагаас санал авч нэгтгэн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.


Нийслэлийн засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжаар удирдамж, нэгдсэн төлөвлөгөө батлагдсан. Тус төлөвлөгөөнд **4** чиглэлийн нийт **126** арга хэмжээг тусгасан.

- | | |
|----------------------|----------------|
| ○ Судалгаа | 4 арга хэмжээ |
| ○ Сургалт | 15 арга хэмжээ |
| ○ Стандарт мөрдүүлэх | 72 арга хэмжээ |
| ○ Хяналт шалгалт | 35 арга хэмжээ |

Захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд газрын даргын 2023 оны А/20 дугаар тушаалаар тус газрыг төлөөлөн ажиллах 29 албан хаагчийг томилж нийслэлийн 9 дүүрэгт дэд ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэгт Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 10 агентлаг, 9 дүүргийн нийт 311 албан хаагч оролцож хамтран ажиллалаа. Мөн олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр 17 удаа мэдээлэл бэлтгэн хүргэв.

1. Орчны аюулгүй байдлын судалгаа: Хүрээлэн буй орчны аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг 2019 оноос эхлэн иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчин бүрдээгүй, стандарт, норм, дүрмийн хэрэгжилт хангалтгүй, орчны аюулгүй байдал алдагдсан талаарх судалгааг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналт тавьж ажиллаж байна.

2023 онд орчны орны аюулгүй байдлын судалгааг 7 сэдвийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэгтэй хамтран хэрэгжүүлж, судалгааны үр дүнг нэгтгэсэн.



Хүснэгт 4. Дүүргүүдээс ирүүлсэн судалгааны дундажийн төрөл

Д/д	Судалгааны төрөл	Нийт	Стандартад нийцсэн		Зөрчил	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Барилгын түр хашаа	382	197	51.6%	185	48.4%
2	Дэд бүтэц /гэрэлтүүлгийн шон/	1332	1002	75.2%	330	24.8%
3	Сургуулийн гадна орчин	305	74	24.3%	231	75.7%
4	Цэцэрлэгийн гадна орчин	241	110	46.6%	131	54.4%
5	Хүүхдийн тоглоомын талбай	976	98	10.0%	878	90.0%
6	Явган зам	1463	592	40.5%	871	59.5%
7	Худалдаа үйлчилгээний байгууллагын гадна орчин	431	153	35.5%	278	64.5%
Нийт:		5130	2226	40.4%	2904	59.6%

2. Хотын стандартын сургалт: Хотын стандартын тогтолцоо, ач холбогдол, үр нөлөөг сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангах, нийслэлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамtran ажиллах хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт **1821** иргэн, аж ахуйн нэгж байгууллагад **18** удаагийн сургалт зохион байгуулав.

Сургалтын агуулгаар авч үзвэл:

- Нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад хотын стандартын тогтолцоо, ач холбогдол, үр нөлөөг танилцуулах, мэдээлэл өгөх сургалт дүүргүүдэд зохион байгуулж нийт 538 төрийн албан хаагч,
- Хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг 10 удаа зохион байгуулж нийт 1283 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл тус тус хамрагдav.



Зураг 8. Дүүргүүдэд зохион байгуулсан сургалтууд

3. Стандарт мөрдүүлэх чиглэлээр: Иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх, хотын өнгө төрх, төлөвлөлт, зохион байгуулалтыг эмх цэгцтэй болгох үндэс суурь нь стандарт юм. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022, 2023 онд нийт 15 бүлгийн 52 хотын стандартыг хэлэлцэн баталж, бүх нийтээр даган мөрдүүлж байна. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 захирамжийн хүрээнд дараах чиглэлүүдэд хотын стандартыг мөрдүүлэх томоохон ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- Байгаль орчин /хог хаягдал/;
- Тохижилт, ногоон байгууламж /явган хүний замын ажил, гадна хаяг, мэдээллийн самбар/;
- Хүүхдийн тоглоомын талбай;
- Гэрэлдүүлэг, гэрлийн шон;


- Инженерийн дэд бүтэц, авто зам, зогсоол;
- Худалдаа үйлчилгээ.

Төвлөрсөн хогийн цэгүүдэд ирж буй хог хаягдлыг дарж устгахад UCS 1705A:2022 “Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж” хотын стандартыг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэд болон нийтийн эзэмшийн гудамж зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгүүдэд 24 цагийн турш хүлээн авч, төвлөрсөн хогийн цэгүүдэд 1089531 тонн хог хаягдал ирснийг ландфилл технологийн дагуу шороогоор хучилт хийв.

Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа 2410 худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүртээмжийг сайжруулах чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэн ажилласан. Зөвлөмжийн дагуу нийт 117 аж ахуйн нэгж байгууллага гадна орчны тохижилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн байна.



Нийслэлийн 9 дүүрэгт худалдаа үйлчилгээ эрхэлж буй 482 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргүүдийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэстэй хамтран хяналт шалгалтыг хийсэн. Үүнээс хүнсний аюулгүй байдлыг хангуулах, гадна хаягийн байгууламж болон гадна тохижилтыг стандартад нийцүүлэх чиглэлээр нийт 143 зөвлөмж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай 25 албан шаардлага тус тус хүргүүлж, газар дээр нь 2 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоосон байна.




Зураг 9. Худалдаа үйлчилгээний байгууллагын гадна орчны хяналт шалгалт

Зөвлөн туслах: Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон он дамжин хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулж мөрдүүлэх, зөвлөн туслах арга стандарт 2020 оноос эхлэн жил бүр зохион байгуулан ажиллаж байна. 2020-2022 онуудад нийт 256 төсөл, арга хэмжээнд стандарт, нормыг мөрдүүлэх талаар газар дээр нь зөвлөн тусалж ажилласан байна.

Тохижилт бүтээн байгуулалтын ажилд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд 2023 онд 132 байршилд зөвлөн тусалж, арга зүйгээр ханганд ажиллав.




Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа явган зам, тохижилтын ажилд UCS 0901B “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороонд нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй явган хүний замын ажилд стандарт аргазүйн зөвлөгөө өгч, иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор видео бичлэг хийж байгууллагын цахим хуудсанд нийтлэв.



Зураг 10. Чингэлтэй дүүргийн 13-р хороо, явган замын ажил

Хяналт шалгалт: Барилга, дэд бүтцийн төрийн хяналт шалгалтын 11 чиглэлээр нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт **698** аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт зохион байгуулж, улсын байцаагчийн зөвлөмж 117, зөрчил дутагдал арилгах тухай мэдэгдэл 66, дутагдал арилгуулах албан шаардлага 17 хүргүүлсэн. Мөн орчны аюулгүй байдлыг алдагдуулсан 50 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоож ажилласан.

Барилга угсралтын чиглэлээр нийт **216** барилгад хяналт шалгалт хийж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2023 оны “Барилгын орчны аюулгүй байдлыг хангуулах тухай 2023/03” дугаартай албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар нийт 27 иргэн аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж, зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил гүйцэтгэсэн 3 аж ахуйн нэгж байгууллага, 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 17.500.000 төгрөгийн торгууль ноогдуулсан.



Зураг 11. ААНБ-уудад хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлж байна

Газрын даргын баталсан 02-13-04/023/17 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу авто зам, гүүрийн байгууламжийн барилга угсралтын 12 ажлыг шалгаж гүйцэтгэгч байгууллагуудад авто замын хяналтын улсын (ахлах) байцаагчийн 12 албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулав.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-иас дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгаан дээрээс үндэслэн тус газраас 9 объектыг сонгон авч хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага гарган хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 захирамжийн хэрэгжилтийн явцыг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд 2 удаа танилцуулж, нэгдсэн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөр эцэслэн нутгийн захиргааны 31 байгууллагаас авч нэгтгэсэн. Төлөвлөгөөний биелэлт 86,4%-тай хэрэгжиж, танилцуулга болон холбогдох бусад материалыг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/1531 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/288 дугаар захирамж: Нийслэлийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй барилгын ажил гүйцэтгэж байгаа 55 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/288 дугаар захирамж гарч Ажлын хэсэг байгуулагдан, холбогдох 7 байгууллагын төлөөллүүдийг оролцуулав.

Газрын даргын баталсан 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Нийслэлийн хэмжээнд шинээр баригдаж буй барилга байгууламж, орчны аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02.13-04/023/04 дугаартай удирдамжийн дагуу тус газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагчид хяналт шалгалт зохион байгуулсан. Шалгалтаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил эхлүүлсэн 50 иргэн, хуулийн этгээдийн 107 блок барилгын судалгаа гарган 2023 оны 6 дугаар сард Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан.



Барилын ажлыг гүйцэтгэхд шаардлагах баримт бичгийн зөрчилтэй баригдсан болон баригдаж буй барилга байгууламжийн 4 ангилсан байдалар:			
Д/Д	Ангилал	Иргэн, аж ахуйн изгж	Блок барилга
1	Барилын ажлыг гүйцэтгэхд шаардлагах баримт бичгийн эхлүүлсэн, ургалжуулсан Онцгой төвөгшилтий /17 давхар, 51м-ээс дээш индэртэй/ буюу 2 харьяаллын дагуу Барилга хот байгуулалтын яаманд шилжүүлж шийдвэр гаргуулах	17	31
2	Барилын угсралтын ажил үргэлжилж байгаа	3	17
3	Барилын угсралтын ажил үргэлжилж байгаа	21	49
4	Барилга угсралтын ажлыг дууссан, ашиглаж байгаа	9	10
	Нийт	50	107

Зураг 12. НЭД-ын зөвлөлийн 2023.06.23-ны өдрийн 11 дүгээр хуралдаан


Улмаар хот төлөвлөлтийн болон барилгын норм ба дүрэмд нийцээгүй 17 барилгыг буулгуулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01/5126 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж, Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 02-00-00/001/01 дугаартай дүгнэлтийг гаргуулав.

Цаашид Салбарын ерөнхий байцаагчийн дүгнэлтийг үндэслэн шүүхийн байгууллагад хандаж буулгах арга хэмжээг авхуулахаар бэлтгэл хангуулж байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/394 дүгээр захирамжийн хэрэгжилт: Захирамжийн 2 дугаар хавсралтаар нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 онд газрын зөрчил арилгаж, стандарт мөрдүүлэх хашаа, хашлагын байршлын жагсаалт батлагдсан. Энэ хүрээнд Баянгол дүүргийн 38, Баянзүрх дүүргийн 4, Сүхбаатар дүүргийн 4, нийт 46 байршлын нийт 7,486.5 метр урт өнгө үзэмжгүй, стандартад шаардлага хангаагүй хашаа, хайс хашлагийг UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандартад нийцүүлэх үүрэг өгөгдсөн.

Стандарт мөрдүүлэх дээрх байршуудад үзлэг шалгалт хийн нөхцөл байдалтай танилцаж, фото зургаар баримтжуулан орон зайн мэдээллийн сан бүрдүүлэв. Зөрчилтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд өнгө үзэмжгүй, стандартын шаардлага хангаагүй хашаа, хашлагыг засаж сайжруулах, зөрчлийг арилгах талаар зөвлөмж хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн.


Лд	Дүүрг	Хороо	Чөлөөлөх газрын байршил, хагас тодорхой баригаа байгуулжийн нор/ны төрөл	Хашааны материал	Тоо эзэмж хашааны урт, метр	Байршилын зураг	Бодит байдал	Хэрэгжүүлсэн арга эзэмж	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8	10	11
БАЯНГОЛДУРЗГ									
1.	Баянгол	2	Манс долгуурин замын урд танд	Бусад хашаа	165			Биецэн зөвлөлийн хүрүүлжсан.	UCS 14108: 2022 стандартын шаардлагыг хүрүүлжсан.
2.	Баянгол	2	Гранд плаза баруун танд	Бусад хашаа	238			Утасар холбогдох стандартын баримт бичгийг хангуулжавар (10 сарын 15-ны дотор хашаагаа солид идээгэн)	UCS 14108: 2022 стандартын шаардлагыг хангуулжавар (10 сарын 15-ны дотор хашаагаа солид идээгэн)
3.	Баянгол	2	Содномонгол ШТС	Бетон сууртлыг төмөр хашаа	278			Газар дээр ашиглак зүргээр баригдтуулсан	Шатахуун түзэх станц



Зураг 13. Хашаа, хашлагын байршил, нэгдсэн судалгаа

Дээрх 46 байршилаас 30 байршилд хашаа, хайсыг стандартад нийцүүлэн засварлуулж, бусад 16 байршилд стандартын дагуу засаж шинэчлэх талаар холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж хяналт тавьж байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Орчны аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/863 дугаар захирамжийн хэрэгжилт: Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилга байгууламж, барилга угсралтын ажил удаан хугацаанд зогссон объектуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2023 оны 8 дугаар сард зохион байгуулсан. Шалгалтаар орчны аюулгүй байдал алдагдсан-90, зөвшөөрөлгүй барилгын суурийн нүх ухсан-16, нийт 106 байршилд холбогдох байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт хийсэн.




Зураг 14. Барилгын суурийн нүх ухсан байршилууд

Зөвшөөрөлгүй суурийн нүх ухсан 2 байршилд зөрчлийн хэрэг нээж, улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага хүргүүлж барилгын суурийн нүхийг булж, нөхөн сэргээлт хийсэн. Нийт 86 байршилд барилгын түр хашааг стандартын шаардлага хангулсан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/804, 806 дугаар захирамжийн хэрэгжилт: Нийслэлийн нутаг дэвсгэрт 7, 8 дугаар сард орсон их хэмжээний борооны улмаас үүссэн үерийн аюул, гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдал зарласан. Энэ хүрээнд тус газраас Нийслэлийн шуурхай штабт 15 албан хаагч, үерийн нөхцөл байдалд 32 албан хаагч ажиллаж үерийн усанд автсан нийт 139 барилгын байршлыг тодорхойлж судалгааг Нийслэлийн онцгой комисст хүргүүлсэн. Мөн үерийн ус хальсан болон халих эрсдэлтэй байршилд нийт 40 машин элс нийлүүлж хариу арга хэмжээ үзүүлэв.



Зураг 15. Нийслэлийн шуурхай штаб



Зураг 16. Үерийн усанд автсан барилгын байршил

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан, хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт: 2023 онд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд 7 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. 5 удаагийн хуралдаанаар 9 асуудлыг танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлagnаж ажилласан.

Хүснэгт 5. НЭД-ын зөвлөлийн хурлаар танилцуулсан асуудлын жагсаалт:

Д/д	Танилцуулсан асуудал	Огноо, дугаар	Үр дүн
1	2 дугаар ээлжид батлуулах 7 бүлгийн 14 хотын стандартыг батлуулах НИТХ-ын тогтоолын төсөл	2023.01.26 Дугаар 01	2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 10 дугаар хуралдаанаар 7 бүлгийн 14 хотын стандартыг хэлэлцүүлж батлуулсан. Хэрэгжилт: 100%

2	Нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээгүйгээр барилга угсралтын ажлыг гүйцэтгэж буй 55 иргэн, хуулийн этгээдийн танилцуулга	2023.03.09 Дугаар 03	Зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажлыг эхэлсэн 55 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулж, танилцуулах Ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын A/288 дугаар захирамжаар байгуулсан. Хэрэгжилт: 100%
3	Иргэдийн эрүүл аюулгүй орчныг бурдүүлэхэд хууль, норм дүрэм, стандартыг хангуулах, хяналт шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн төсөл		Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр "Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" A/242 дугаар захирамжаар 4 бүлэг 126 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан. Хэрэгжилт: 100%
4	Нийслэлийн нутаг дэвсгэрт холбогдох эрх бүхий байгууллагаас барилгын ажлын зөвшөөрөл авалгүй барилга угсралтын ажил эхлүүлсэн, гүйцэтгэсэн 50 иргэн, хуулийн этгээдийн 107 блок барилга, цаашид авах арга хэмжээ	2023.06.23 Дугаар 11	Хот төлөвлөлтийн болон барилгын норм ба дүрэмд нийцээгүй 17 барилгыг буулгуулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01/5126 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж, Салбарын ерөнхий байцаагчийн дүгнэлтийг гаргуулсан. Хэрэгжилт: 100%
5	"Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бурдүүлэхэд хууль, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах" тухай 2023 оны A/242 дугаар захирамжийн биелэлт, хэрэгжилтийн явц	2023.08.24 Дугаар 15	Захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 7 дүүргийн дэд ажлын хэсгүүдтэй уулзалт зохион байгуулж, үр дүнг газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хуралд танилцуулсан. Захирамжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, ажлын үр дүн танилцуулга, нэгдсэн төлөвлөгөөний тайланг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Хэрэгжилт: 100%
6	"Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам"-ын төсөл		Хуралдааны тэмдэглэлээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн удирдлага солигдсонтой холбогдуулан журмын төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2023 оны 12 дугаар сарын 26-нд дахин танилцуулсан. Хэрэгжилт: 50%
7	Хотын стандартын хэрэгжилт, 3 дугаар ээлжид батлуулах 10 бүлгийн 24 хотын стандартын төсөл	2023.12.26 Дугаар 20	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн A/02 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, хотын стандартыг хянан тохиолдуулах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион боловсруулах төлөвлөгөө боловсруулж байна. Хэрэгжилт: 30%

8	“Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төсөл		Журмын төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Журмын хавсралт болох “Хотын стандартыг боловсруулах арга зүйн заавар” боловсруулж, Нийслэлийн Засаг даргын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмонд хянуулахаар ажиллаж байна. Хэрэгжилт: 30%
9	Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдсан барилга байгууламж, барилгын их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааны үр дүн		Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/861 дүгээр захирамжийг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Хэрэгжилт: 30%
10	2023 онд хийсэн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн		Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж, танилцуулахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулж батлуулсан. Хэрэгжилт: 30%

Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт: 2023 онд 35 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс тус газарт нийт 185 үүрэг даалгавар өгөгдсөнийг тухай бүр хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг Ulaanbaatar.mn, ERP Хяналт-шинжилгээ үнэлгээ цахим системд тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан.


Хүснэгт 6. Шуурхайн үүрэг даалгаврын хэрэгжилт

Шуурхай хуралдааны тоо	Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо			Биелэлтийн хувийн дундаж
	Нийт үүрэг даалгавар	Байгууллагад өгөгдсөн /нийт/	Үндсэн хэрэгжүүлэх	
35	543	188	59	81.7%

2.3. Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд төвийн 6 дүүргийн хэмжээнд үерийн хамгаалалтын барилга байгууламжийн 60 гаруй байршил, халиа, дошин ихээр үүсдэг үерийн хамгаалалтын барилга байгууламж дээр баригдсан гүүрэн байгууламжийн 22 байршилд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын ахлах

байцаагчийн 10 заалттай 4 албан шаардлага, 12 заалттай 3 зөвлөмжийг Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаа.



Зураг 17. Хяналт шалгалтын яөц

Хяналт шалгалтын ажлын танилцуулгыг Нийслэлийн Онцгой комисст 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлж, цаашид авах арга хэмжээний саналыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, дүүргүүдийн Засаг дарга нар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албандаа тус тус хүргүүлсэн.

2.4. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд наортай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт

2023 онд Нийслэлийн Засаг дарга болон Засгийн газартай байгуулсан дараах 6 салбарт хамтран ажиллах гэрээнд газрын чиг үүрэгт хамаарах ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг хангуулсан. Гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож биелэлтийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

Хүснэгт 7. Гэрээний хэрэгжилт

Д/д	Салбар, чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ			Биелэлтийн дундаж хувь	
		Нийт	Үүнээс:		Хагас жил	Бүтэн жил
			Үндсэн	Хамтран		
1	Монгол улсын шадар сайд	3	1	2	-	80%
2	Барилга, хот байгуулалтын сайд	10	5	5	93%	94%
3	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3	-	3	40%	80%
4	Эрчим хүчний сайд	5	5	-	90%	100%
5	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	3	3	-	-	100%
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	1	1	-	-	100%
Нийт:		25	15	10	74.3%	92.3%

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт

3.1.1. Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн мөрдөгдөж эхэлснээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бүх нийтээр дагаж мөрдөх “хотын стандарт”-ыг бий болгон батлуулах хууль эрх зүйн боломж нээгдсэн.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9.4.2-т Хотын нэгдсэн стандартыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт- шинжилгээ хийх тогтолцоог бий болгооор зорилт тодорхойлогдсон.

Энэ зорилтын хүрээнд холбогдох хууль тогтоомжид хотын стандартын талаар зохих зохицуулалтыг тусгаснаар хотын стандартын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндэс суурь тавигдсан.

№	Хуулийн нэр	Холбогдох заалт
1	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	24.1 Нийслэлийн чиг үүрэг 24.1.15 “хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт” гэсэн чиг үүрэг тусгагдсан
2	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	21.1 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 21.1.3 нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт заавар батлах 32.2 Нийслэл хотын оршин суугч дараах үүрэгтэй: 32.2.3 нийслэл хотын дүрэм, стандартыг дагаж мөрдөх
3	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль	10¹ дүгээр зүйл. Хотын стандарт. 10 ¹ .1. Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно. 10 ¹ .2. Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор хотын стандартыг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төсөл боловсруулав. Уг журмын төсөлд Стандарт, хэмжил зүйн газар, Нийслэлийн нутгийн захиргааны 12 байгууллагаас ирүүлсэн нийт 75 тухайлсан саналыг авч тусгасан.

Журмын төслийг 5 бүлэг, 20 зүйлтэйгээр боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанаар танилцуулсан. Журмын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны эхний улиралд багтаан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авах хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Журмын хавсралт болох “Хотын стандартыг боловсруулах арга зүйн заавар” боловсруулж байна.

Хотын стандартыг боловсруулах: Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл байдлыг хангуулах нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 22 бүлгийн 97 хотын стандартыг боловсруулан үе шаттайгаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж байна.

Хотын стандартыг боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг 2022 оноос хойш 2 удаа байгуулагдаж, нийт **15** бүлэг **52** хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулаад байна.

Хүснэгт 8. Батлагдсан хотын стандартын жагсаалт

Хугацаа	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Д/д	Бүлгийн нэр
I ЭЭЛЖ 9 бүлгийн 38 хотын стандарт /2022 он/	НЗД-ын 2021 оны А/1033 дугаар захирамж	1	Нийгмийн дэд бүтэц
		2	Хот төлөвлөлт, хот байгуулалт
		3	Худалдаа үйлчилгээний гадна орчин
		4	Нийтийн эзэмшилийн эд хөрөнгө
		5	Зорчигч тээврийн үйлчилгээ
		6	Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл
		7	Хог хаягдлын менежмент
		8	Иж бүрэн гудамж
		9	Ногоон байгууламж
II ЭЭЛЖ 7 бүлгийн 14 хотын стандарт /2023 он/	НЗД-ын 2022 оны А/1305 дугаар захирамж	1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц
		2	Үер, борооны усны байгууламж
		3	Гудамж, зам, барилга байгууламжийн хаягжилт
		4	Нийгмийн дэд бүтэц
		5	Бие даасан инженерийн дэд бүтэц
		6	Дуу чимээний бохирдол
		7	Барилгын хийц, эдлэхүүн, техник

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1305 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд 2023 оноос мөрдүүлэх хотын стандартын төслийг боловсруулах, батлуулах ажлын хэсэг байгуулагдаж, Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ ахлан ажилласан.

Ажлын хэсгийн зүгээс хотын стандартын дараагийн хэсэг буюу 7 бүлгийн 14 хотын стандартын төслийг хянаж, Стандарт хэмжил зүйн газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар болон нийслэлийн нутгийн захиргааны **21** байгууллага, харьяа **260** байгууллага, мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг судалж тусгасан.

Хотын стандартын төслийд олон нийтээр хэлэлцүүлэн санал авах хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуул Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөл нийт 320 гаруй хүн оролцож санал, хүсэлтээ илэрхийлсэн.



Зураг 18. Ажлын хэсгийн хурал



Зураг 19. Хотын стандартын хэлэлцүүлгийн үеэр /2023.01.06/

Хотын стандартыг батлуулах: Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар 7 бүлгийн 14 хотын стандартын төслийг Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхийг үүрэг болгосон.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Хүний хөгжлийн хороо, Хот байгуулалт, дэд бүтцийн хороо, XYH намын бүлэг, АН-ын бүлгийн хурал, МАН-ын бүлгийн хурлааар 2023 оны 03 дугаар сарын 24-29-ний өдрүүдэд хотын стандартын төслийг танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус Х хуралдаанаар **7** бүлгийн **14** хотын стандартыг хэлэлцэн баталсан.

Батлагдсан хотын стандартыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хамтран ажиллах талаар Нийслэлийн нутгийн захиргааны нийт 88 байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/697 тоот албан бичиг хүргүүлэв.



Хотын стандартын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ: Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй тохижилт бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжилтийг хянах, хүлээн авах үе шатуудад батлагдсан хотын стандартын хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ хийх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор 2023 оны 11 дүгээр сард нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа 31 байгууллагад дараах 4 агуулгаар мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн.

- Хотын стандартыг мөрдүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажлын товч мэдээлэл;
- Хотын стандартуудыг мөрдүүлэхэд тулгамдаж буй асуудал;
- Стандартын хэрэгжилтийг сайжруулах талаарх санал;
- Шинэчлэн боловсруулах хотын стандартын санал.

Албан бичгийн хариуг 25 байгууллагаас ирүүлж, ажлын тайлан мэдээллийг нэгтгэлээ. Нийслэлд хэрэгжиж буй ажил, үйлчилгээг төлөвлөх, гүйцэтгэх, хүлээн авах, ашиглалтын гэсэн үндсэн 4 үе шатанд хотын стандартыг мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 9. Хотын стандартын хэрэгжилтийн явц

№	Үе шат	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн	Холбогдох байгууллага
1	Төлөвлөлт /Хотын стандартыг бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг төлөвлөхөд тусгах/	Хотын стандартыг тусгасан архитектур төлөвлөлтийн даалгавар	1056	ХБХГ
		Тендерийн бичиг баримт, гэрээний тусгай нөхцөл	542	НХААГ, дүүргүүд

		Техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тусгах /35 хотын стандарт/	100%	УБЗАА, НХОГ дүүргүүд
2	Гүйцэтгэлийн хяналт /ажлын гүйцэтгэлийн явцад стандарт мөрдүүлэх/	Бүтээн байгуулалт, тохижилтын ажлын явцад зөвлөн туслах, арга зүйгээр хангах /ААНБ, иргэд/	1964	ХСХГ, УБЗАА, дүүргүүд
		Захиалагчийн хяналт тавих /ажлын тоо/	654	УБЗАА, НХОГ дүүргүүд
		Хяналт шалгалт хийх /барилгын гадна аюулгүй орчин, хашаа хайс/	457	Хяналтын байгууллагууд
3	Хүлээн авах Комисс ажиллахад стандарт хангуулах	Барилга ашиглалтад хүлээн авах	915	ХСХГ
		Тохижилт, засварын ажил	713	ХСХГ
4	Ашиглалт /Засвар үйлчилгээний ажлын явцад стандарт хангуулах/	Орчны аюулгүй байдлын судалгаа /сэдэв/	12	ХСХГ, дүүргүүд
		Хяналт шалгалт	1611	Хяналтын байгууллагууд

Байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээнд үндэслэн дүгнэхэд хотын стандартыг бүрэн хэрэгжилттэй мөрдүүлэхэд ажил, үйлчилгээг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжилтийг хянах, хүлээн авах үе шатуудад гарч буй алдаа дутагдлыг дараах байдлаар сайжруулбал үр дүнтэй гэж үзэж байна.

Хүснэгт 10. Хотын стандартын хэрэгжилтийг сайжруулах

№	Үе шат	Зорилтот үйл ажиллагаа	Дутагдалтай үйл ажиллагааг сайжруулах санал
1	Төлөвлөлт	Төлөвлөлтийн үе шатад хотын стандартыг бүрэн тусгасан хэрэгжилт	Ажлын зураг төслийг батлах түвшинд нарийвчлан хянаж баталгаажуулсан байдлыг сайжруулбал стандартын хэрэгжилт төлөвлөлтийн үе шатад бүрэн хэрэгжих боломж бүрдэнэ.
2	Гүйцэтгэлийн хяналт	1. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхэд хотын стандартыг мөрдүүлэх 2. Зөвлөн туслах, аргазүйгээр хангах	Зөвлөн туслах, аргазүйгээр хангах үйл ажиллагаанд хийгдэж буй бүх ажилд биечлэн хүрч ажиллах нөөц боломжийг нэмэгдүүлж, хяналтын тогтолцоог сайжруулбал гүйцэтгэлийн хяналт сайжрах боломж бүрдэнэ.
3	Хүлээн авах	1. Улсын комисс стандарт хангуулах 2. Бараа, үйлчилгээг хүлээн авч, гэрээ дүгнэх	Захиалагч, зураг төсөл зохиогчдын хяналтыг үр дүнтэй, чанартай хэрэгжүүлбэл ашиглалтад хүлээн авахад гарах зөрчлийг бууруулах боломж бүрдэнэ.

4	Ашиглалт	1. Орчны аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах 2. Хяналт шалгалтыг зохион байгуулах	1. Гудамж, зам талбайн аюулгүй, хэвийн байдлыг хангуулахад ажиллах хүч, машин тоног төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх замаар сайжруулах боломж бурдэнэ. 2. Хүүхдийн эрүүл аюулгүй орчныг бурдүүлэхэд СӨХ-дуудын үйл ажиллагааны чадавх, хариуцлага харилцан адилгүй байгаагаас хотын стандартыг мөрдүүлэхэд хүндэрэл үүсч байгаа бөгөөд ашиглалт засвар үйлчилгээ ургал зардлыг шийдвэрлэх замаар орчны эрсдэлийг бууруулах боломж бурдэнэ.
---	----------	--	---

Хотын стандарт батлуулах 3 дахь ээлжийн ажил үргэлжилж, **10** бүлгийн **24** хотын стандартын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан.

№	Бүлгийн нэр	Хотын стандартын нэр
1	Хот төлөвлөлт, хот байгуулалт	Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага
2		Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага
3	Үер борооны усны байгууламж	Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага
4	"Иж Бүрэн Гудамж"	"Иж бүрэн гудамж"-ийг төлөвлөх, байгуулах, бодлого зарчим
5		Гудамжны төрөл ангилал, тавигдах шаардлага
6		Нийтийн тээврээр зорчих гудамжны төлөвлөлт хийх удирдамж
7		Авто машинаар зорчих гудамжны төлөвлөлт хийх удирдамж
8		Ногоон байгууламж бүхий гудамж төлөвлөх түүнд хэрэглэгдэх мод, бут, сөөг сонгох ерөнхий шаардлага
9		Гудамжны уулзварын төлөвлөлт хийх удирдамж
10		Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлага
11	Нийгмийн дэд бүтэц	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага
12		Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага
13		Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага
14		Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл
15		Автомашин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлага
16	Худалдаа үйлчилгээний газрын гадна орчин	Авто засварын үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага

17		Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага
18	Барилгын хийц, эдлэхүүн, техник	Орон сууцны барилгын дулаалга, гадна фасадад тавигдах шаардлага
19		Орон сууцны дээврийн ажилд тавигдах шаардлага
20	Хог хаягдлын менежмент	Хоёрдогч түүхий эд авах цэгт тавигдах шаардлага
21	Авто зам, замын байгууламж	Хотын авто зам төсөллөх ерөнхий шаардлага
22		Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад тавигдах ерөнхий шаардлага
23	Чанарын дэд бүтэц	Хотын стандарт боловсруулах заавар
24	Зорчигч тээврийн үйлчилгээ	Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлага

Мөн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан нийтийн тээврийн хэрэгсэл, ил зогсоолын төрөл, тэдгээрт тавих шаардлагын тухай дараах 3 төрлийн хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар өргөн барьж батлуулахаар холбогдох 5 байгууллагаас санал авч байна.

- UCS 1603B “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага”,
- UCS 1601B “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага”,
- UCS 0902B “Тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага”.

Дээрх хотын стандартын төслүүдийг хянан тохиолдуулах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

3.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/239, А/861 дүгээр захирамжийн дагуу улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн барилга байгууламж, түүний гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн зохион байгуулан ажиллаж байна.


Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн байгууллага болон төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia портал сайтаар дамжуулан 2023 оны байдлаар барилга-479, их засвар, шинэчлэлт, тохижилт-310, цахилгаан хангамж-635 нийт **1424** хүсэлтийг хүлээн аван судалж,

барилга байгууламжийг ашиглалтад оруулах **1055** байршилд комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, **746** дүгнэлт баталгаажуулан ажилласан.

№	Төрөл	Ирүүлсэн хүсэлт	Ажилласан комисс	Дүгнэлт баталгаажсан
1	Барилга байгууламж	479	279	213
2	Их засвар, шинэчлэлт, тохижилт	310	282	164
3	Цахилгаан хангамж	635	494	369
	Нийт	1424	1055	746



Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн орон зайн мэдээллийн сан үүсгэж, комиссын дүгнэлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудас <https://standard.ub.gov.mn>-д тухай бүр баяжуулан ажиллаж байна.



1.1.3. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар барилга, дэд бүтцийн чиглэлээр 11 хяналтын чиг үүрэг бүхий 38 улсын (ахлах) байцаагчдыг тус газарт шилжүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-ын дагуу хяналтын улсын (ахлах) байцаагчийн эрх олгуулах тухай хүсэлтийг холбогдох 5 яаманд хүргүүлж шийдвэрлүүлэн, төрийн хяналт шалгалтыг хэвийн зохион байгуулан ажиллаж байна.

№	Хяналтын чиг үүрэг	Орон тоо		Эрх авсан салбарын яам
		Үндсэн	Одоо ажиллаж байгаа	
1	Барилгын техникийн хяналт	11	7	Барилга, хот байгуулалтын яам
2	Хот төлөвлөлтийн хяналт	3	2	
3	Өргөх байгууламжийн хяналт	3	2	
4	Ус хангамж, ариутгах татуургын хяналт	3	3	
5	Барилгын материалын хяналт	2	2	
Нийт:		22	18	1 яам
6	Эрчим хүч (цахилгаан)-ний хяналт	3	2	Эрчим хүчний яам
7	Эрчим хүч (дулаан)-ний хяналт	3	2	
8	Авто замын хяналт	3	3	Зам, тээврийн хөгжлийн яам
9	Авто тээврийн хяналт	2	2	
10	Газрын тос, хийн хяналт	3	3	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
11	Харилцаа холбооны хяналт	2	0	Цахим хөгжил харилцаа холбооны яам
Нийт:		16	12	4 яам
Бүгд:		38	32	5 яам

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн 4 төрлийн хяналт шалгалтыг холбогдох яамдын Салбарын хяналтын газрын удирдамж болон газрын даргын хяналт шалгалтын удирдамж, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу зохион байгуулж, 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт **4550** объектыг хяналт шалгалтад хамруулсан байна.

Хүснэгт 11. Хяналт шалгалтын тоон үзүүлэлт

№	Шалгалтын төрөл	Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо
1	Төлөвлөгөөт хяналт шалгалт	190
2	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт	700
3	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт	3219
4	Гүйцэтгэлийн хяналт шалгалт	441
Нийт:		4550

Төлөвлөгөөт хяналт шалгалт:

Барилга, дэд бүтцийн салбар чиглэлээр салбарын хяналтын <http://shilenkhyanalt.gov.mn> цахим системд нийт 2065 объектыг эрсдэлийн үнэлгээг оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 190 объектод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав.

Хүснэгт 12. Төлөвлөгөөт хяналт шалгалтын хэрэгжилт

№	Салбар	Хяналтын чиглэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	
1	Барилга	Барилгын техник	81	81	100%	
2		Хот төлөвлөлт	27	18	100%	
3		Өргөх байгууламж	18	18	100%	
4		Ус хангамж, ариутгах татуурга	27	20	100%	
5		Барилгын материал	18	18	100%	
			171			
6	Дэд бүтэц	Эрчим хүч (цахилгаан)	6	6	100%	
7		Эрчим хүч (дулаан)	9	9	100%	
8		Авто зам	9	9	100%	
9		Авто тээвэр	12	12	100%	
10		Газрын тос, хий	9	9	100%	
11		Харилцаа холбоо	5	0	0%	
			50	45	80%	
Нийт:			221	190		

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын улсын Ерөнхий байцаагч, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын Ерөнхий байцаагч нарын хамтарсан 2023 оны 02-00/13, 07-00/07 удирдамж болон Барилга, хот байгуулалтын яамны Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны “Төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 02-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн 93% нь бага эрсдэлтэй, 5 хувь нь дунд эрсдэлтэй, 2 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн ба нийт улсын байцаагчийн 60 зөвлөмж, 30 албан шаардлага, 2 хялбаршуулсан журмаар зөрчлийн хэрэг нээн ажилласан байна.

Эрчим хүчний яам Салбарын ерөнхий байцаагчийн 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 11/04 дугаартай удирдамжийн хүрээнд орон сууцны гадна эрчим хүчний байгууламжийг мэргэжлийн байгууллагад хүлээлгэж өгөөгүй 6 объектод шалгалт хийж шугам тоноғлол, борлуулалтыг мэргэжлийн байгууллагад шилжүүлж 890 хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчний үнийг айл өрхийн тарифаар тооцуулан төлөх нөхцөлийг хангуулж ажиллалаа.

Газрын даргын баталсан 2023 оны “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/16 дугаартай удирдамжийн дагуу асфальтбетон заводын үйл ажиллагааны 10, авто зам, замын байгууламжийн 10, нийт 20 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 13 албан шаардлага, 1 дүгнэлт, 2 зөвлөмжийг аж ахуйн нэгжид хүргүүлэн, 1 аж ахуйн нэгжид 5,0 сая төгрөгийн торгууль ногдуулж ажилласан байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 06-00/005 дугаартай удирдамжийн дагуу СХД, БГД, ЧД, БЗД-үүдийн нутаг дэвсгэрт байрлах 9 ШТС-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Батлагдсан зураг төсөлгүй барьж, улсын комиссын актгүй, шатахуун хадгалж түгээсэн зөрчил гаргасан 6 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 6000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулж, шатахуун хадгалах савыг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, аянга зайлнуулагч, тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлээгүй зэрэг стандарт норм дүрмийн хэрэгжилт хангаагүй 3 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн албан шаардлагыг тус тус хүргүүлж биелэлтийг хангуулж ажиллалаа.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Барилгын хяналтын чиглэлээр: Барилга, хот байгуулалтын яамны салбарын хяналтын газраас баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 6 удирдамжийн хүрээнд 621 аж ахуйн нэгж, байгууллага, Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан удирдамжийн хүрээнд 421, газрын даргын баталсан 2 удирдамжийн хүрээнд 121, нийт 1163 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн.


№	Хяналтын чиглэл	Аж ахуйн нэгжийн тоо	Ногдуулсан торгууль
1	Барилгын техник	117	179.0 сая
2	Хот төлөвлөлт	57	150.0 сая
3	Өргөх байгууламж	119	9.8 сая
4	Ус хангамж, ариутгах татуурга	Цэвэрлэх байгууламж, үерийн далан сувгийн 1236 км далан сувагт хяналт шалгалт хийсэн.	
5	Барилгын материал	102	76.0 сая

Дэд бүтцийн хяналтын чиглэлээр: Нийт 52 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Эрчим хүчний хяналтын чиглэлээр 17 ААНБ;
- Авто замын чиглэлээр 6 төсөл арга хэмжээ;

- Авто тээврийн чиглэлээр 21 иргэн, ААНБ;
- Газрын тосны чиглэлээр 8 иргэн, ААНБ-д тус тус хяналт, шалгалт хийж, 261 зөрчил илрүүлэн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн гүйцэтгэлийн шалгалт хийж хуулийн хэрэгжилтийг 76.2%-89.9% хангулан ажиллалаа.

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2023 оны “Урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-00/08 дугаартай удирдамж, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 045 дугаартай удирдамжийн дагуу арматур импортлогч, үйлдвэрлэгч 23 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, материалын дээжийг итгэмжлэгдсэн лабораториудад өгч, стандартад нийцээгүй 1300 тн арматурыг дахин боловсруулахаар улсын байцаагчийн албан даалгавар хүргүүлж үйлдвэр рүү буцаан татуулсан. Шалгалтаар тохирлын гэрчилгээгүй ААНБ-уудад улсын байцаагчийн 16 албан шаардлага хүргүүлж, стандартын шаардлага хангаагүй арматур үйлдвэрлэсэн, борлуулсан зэрэг 8 ААНБ, иргэнд зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг явуулж, 40,0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.



Зураг 20. Арматур үйлдвэрлэгч ААНБ-уудад хийсэн хяналт шалгалт

Газрын даргын баталсан 2023 оны “Урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/14 дугаартай удирдамжийн дагуу нийслэлийн нутаг дэвсгэрийн 8 байршилд шинээр хийгдсэн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл, угсралтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн. Хяналт шалгалтын явцад нийт 39 дутагдлыг илрүүлж, 12 дутагдлыг газар дээр нь арилгуулж, ААНБ-ын удирдлага, инженер техникийн ажилтнуудад шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгах, үйл ажиллагаагаа сайжруулах, ашиглалтын үеийн норм, дүрмийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагаа болон техник ашиглалтын дүрмийн хэрэгжүүлж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг 6 ААНБ-д өгч ажиллалаа.

Эрчим хүчний яамны 2023 оны 11/06 дугаартай “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай”, 2023 оны 11/06 дугаартай “Дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-иас дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст буй иргэн, аж ахуйн нэгжийн судалгаанд үндэслэн 9 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ШТС-уудын сав тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд Тэс петролиум ХХК, Ойн бирж ХХК, Шунхлай трейдинг ХХК, Сод монгол групп ХХК, Монсуль ХХК-иудын 10 ШТС-ын нийт 37 ширхэг /насжилт өндөртэй/ ган савны акт, баримт бичиг, техник ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийж 2000 оноос өмнөх, 10-аас дээш жилээр ашиглаж байгаа шатахуун хадгалах саванд техникийн магадлал хийлгэн, ашиглалтын аюулгүй ажиллагааг хангуулах үүрэг даалгаврыг тус газруудад өгч, хуучирсан 20 савнуудыг солиулсан. Дээрх хуучин савнуудыг шинэ саваар сольсноор шатахууны чанартай холбоотой гомдол 47%-иар буурсан.

Газрын даргын баталсан 2023 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/10 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар хотод аюултай хог хаягдал /ашиглалтын хугацаа дууссан автомашины аккумулятор, батарей, ашигласан тос/ цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах ажил, үйлчилгээ эрхэлж буй 21 аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Аюултай хог хаягдлын менежмент хотын стандартын хэрэгжилтийг хангуулах зөвлөмж өгч ажиллалаа.




Зураг 21. Аюултай хог хаягдал цуглуулж буй байршилууд

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, Газрын даргын баталсан 2023 оны “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 7 удирдамжийн хүрээнд байгууллагад дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, хуулийн хугацаанд албан бичиг, улсын байцаагчийн эрх зүйн баримт бичгээр хариуг хүргүүлэн ажиллалаа. 2023 онд нийт 3219 өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн.

Өргөдөл гомдлын 1147 буюу 96.6%-г, албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн 1313 буюу 92.7%-ийг бүрэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд 695 албан бичиг боловсруулан хариуг хүргүүлж, мөн улсын байцаагчийн эрх хэмжээний хүрээнд зөвлөмж 106, албан шаардлага 160, албан даалгавар 155, дүгнэлт 198, акт 10 нийт 629 эрх зүйн баримт хариуг иргэн, ААНБ-д хүргүүлж, зөрчилтэй 155 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Зөрчлийн тухай хуулийн холбогдо заалтуудын дагуу нийт 384,7 сая төгрөгийн тorguuль ногдуулж, Улсын /ахлах/ байцаагчийн албан даалгавар хүргүүлж ажилласан байна.



Хэрэг бүртгэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа

Зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу судлан шийдвэрлэх, зөрчлийн хэргийг нээх, шийдвэрлэх ажиллагааг Нийслэлийн Прокурорын хяналтан дор явуулж байна. Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны А/77 дугаар тушаалаар батлагдсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн загвар, жагсаалт”-ын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулан 2023 онд нийт 186 иргэн, хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулсан. Үүнээс:

- Зөрчлийн хэрэг нээсэн 10;
- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 176;
- Татгалзсан 5.

Нийт 489 сая төгрөгийн торгууль, 31.6 сая төгрөгийн нөхөн төлбөр ноогдуулсан байна.


3.2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах хүрээнд 2023 оны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т 4 бүлгийн 12 арга хэмжээг төлөвлөн газрын даргаар 2023 оны 02 дугаар сарын 22-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу дараах арга арга хэмжээг зохион байгуулав.

1. Албан тушаалын тодорхойлолт боловсруулж, батлуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649, 2023 оны А/304 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж Төрийн хяналт шалгалтын Барилга, Дэд бүтцийн чиг үүрэг шилжин ирсэн. Энэ хүрээнд газрын даргын 2023 оны А/01, А/05 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолт боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, газрын шинэчлэгдсэн дүрэм, Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн шинээр батлуулах 44, өөрчлөн батлуулах 2, төрийн захиргааны нийт 46 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулсан.

Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн цахим систем <https://hrm.csc.gov.mn/>-д шивж, Төрийн албаны зөвлөл болон Нийслэл дэх салбар зөвлөлөөр тус тус хянуулж, албан тушаалын тодорхойлолтын харьцуулалт, тогтоолын төсөл, хянасан тухай танилцуулга зэргийг бэлтгэж 2023 оны 5, 7 дугаар сард хянуулж, танилцуулсны үр дүнд Албан тушаалын тодорхойлолт хянан батлах комиссын хурлаар хэлэлцүүлж 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 354, 355 тогтоолоор батлах зөвшөөрөл олгогдож, газрын даргын A/44, A/45 дугаар тушаалаар баталсан.



2. Албан хаагчдын цалин хөлс, зэрэг дэвийг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 487, 488, 491 дүгээр тогтоолын хүрээнд тус газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 2023 оны “Үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” А/03 дугаартай тушаалаар, төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг шинэчлэн тогтоох тухай” А/17 тушаалаар тус тус шинэчлэн тогтоосон.

Төрийн жинхэнэ албаны болзол, шаардлага хангасан 8 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдлийг шинээр болон ахиулан олгуулах санал боловсруулж, 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/126 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай” А/511 дүгээр захирамжаар тус газрын 8 албан хаагчийн зэргийн нэмэгдлийг олгуулсан.

Үүнд шинээр зэрэг дэв олгогдсон шинээр 5, ахиулан олгосон 3 албан хаагч байв. Дээрх албан хаагчдын зэргийн нэмэгдлийг Хүний нөөцийн удирдлагын системд оруулж 2023 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцон олгуулж эхэлсэн.

3. Төрийн албаны сул орон тооны захиалга хүргүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг өргүүлсэн талаар:

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзول болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2 дахь заалтын хүрээнд Төрийн жинхэнэ албан хаагчийг нутгийн захирагааны байгууллага хооронд шилжүүлэн авах зар, мэдээллийг байгууллагын цахим хуудас болон нутгийн захирагааны байгууллагын дотоод удирдлагын системээр 6 удаа нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтаар удирдах, гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг 18 албан хаагчийг жинхлэн томилж төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэн ажилласан.

“OPEN - EXAM” ШАЛГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ										хотын стандарт	1/3	^	v	x	
										услуги	дан настру				
23	Гор*****	БА*****	ур***2111	Хотын стандарт	ЗАХИАЛГААНЫ ГАЗР	Барилгын стандарт, аюултой байдлын зандлын цэгтэс	Удирдах	T3 + 4	Хамгийн дараа (Уснын аялан байдалын)	Батлагдсан	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15	
24	Еи****	НД*****	ен***0512	Хотын стандарт	ЗАХИАЛГААНЫ ГАЗР	Дэл бүүцийн стандарт, зандлын цэгтэс	Удирдах	T3 + 4	Хамгийн дараа (Уснын аялан байдалын)	Батлагдсан	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15	
25	Од**	ОЧ*****	из***0301	Хотын стандарт	ЗАХИАЛГААНЫ ГАЗР	Дэл бүүцийн стандарт, зандлын цэгтэс	Удирдах	T3 + 4	Хамгийн дараа (Уснын аялан байдалын)	Батлагдсан	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15	
26	Зу****	Дж*****	чн***1415	Агаар сонмын бомидогтой таних газар	Хийнчилгээний цэгтэс	Хийнчилгээний цэгтэс	Удирдах	T3 + 4	Хийнчилгээний цэгтэйн дараа байхад орчны зандлын угсаан аялан байдалын	Батлагдсан	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15	
27	Еи*****	Уг*****	шн***0612	Агаар сонмын бомидогтой таних газар	Хийнчилгээний цэгтэс	Хийнчилгээний цэгтэс	Удирдах	T3 + 4	Хийнчилгээний цэгтэйн дараа байхад орчны зандлын угсаан аялан байдалын	Батлагдсан	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15	
28	Бог**	Ан*****	вн***2314	Замчилжүүлийн газар	Бодлогого төхөөллийн цэгтэс	Бодлогого төхөөллийн цэгтэс	Удирдах	T3 + 4	Бодлогого төхөөллийн цэгтэйн дараа	Бодлогого төхөөллийн цэгтэйн дараа	[Анкетшигээсан]	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15
29	Га***	БА*****	сн***0619	Замчилжүүлийн газар	Бодлогого төхөөллийн цэгтэс	Бодлогого төхөөллийн цэгтэс	Удирдах	T3 + 4	Бодлогого төхөөллийн цэгтэйн дараа	Батлагдсан	[изалтэй]	Гаригдлын нийслэлийн нутгийн захиргааны цолцлогбор байр 4 дүгээр дахар	4 дүгээр дахар шалтгалин тамир	2023-11-15	

Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 22, 23, 26, 27 дугаар зүйлд тавигдсан шаардлага нөхцөл болзлыг хангасан, Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захирагааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын үндэслэн тангараг өргүүлэх албан хаагчийн судалгаа хүргүүлж, 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр тус газрын 12 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.



4. Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах, тэдгээрийн мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийг анх томилогдсон үеэс сургаж, хөгжүүлэх, шатлан дэвшихэд нь тухайн албан тушаалыг эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэн мэргэшүүлэх зорилгоор байгууллагад шинээр томилогдсон болон шилжин ирж ажиллаж буй албан хаагчдыг богино хугацаанд дадлагажуулах “Шинэ албан хаагчдыг чиглүүлэх хөтөлбөр”-ийг газрын даргын 2023 оны А/57 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжүүлж эхлүүлсэн.

Удирдлагын академиас зохион байгуулж буй мэргэшүүлэх дараах багц сургалтад хамруулсан. Үүнд:

- Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн сургалтад 1 албан хаагч;
- Төрийн захиргааны ахлах түшмэлийн сургалтад 4 албан хаагч;
- Төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч;
- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 8 албан хаагч тус тус хамрагдаж гэрчилгээ авсан.

Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн төлөвлөгөөт сургалтад 45, Худалдан авах ажиллагааны сургалтад 21, Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартын Дотоод аудитор бэлтгэх сургалтад 3, Мэргэжлийн сургалт семинарт 8, Олон улсын туршилага судлах семинарт 1 албан хаагчийг тус тус хамруулсан.

Олон улсын туршилага судлах чиглэлээр: Английн Лондон хотод 2023 оны 09 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хүртээмжтэй дэд бүтэц” сэдэвт уулзалтад Хотын стандарт хяналтын газрын Хотын хөгжлийн стандартын хэлтсийн мэргэжилтэн М.Амарзаяа, Түгээмэл хөгжил төвөөс Н.Тамирхүү нар оролцсон. Уулзалтын үеэр Улаанбаатар хотын хүртээмжтэй дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал, төрөөс баримталж буй бодлого шийдвэр, тулгарч буй буй хүндрэл бэрхшээлийг танилцуулж, “Global Inclusive design” үндэсний хэмжээний тайланд хөгжиж буй орнуудад зориулж нэгдсэн зөвлөмж боловсруулж ажиллалаа.



Зураг 22. “AT2030 Хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах нь”- Лондон хот

Байгууллагын мэдээллийн цаг арга хэмжээнд сургалтын байгууллагаас сургагч багш, лекторыг урьж, “Байгууллагын соёл ба хандлага”, “Эрүүл амьдралын хэв маяг” сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж нийт 79 албан хаагчдыг хамруулсан байна.




Зураг 23. “Эрүүл амьдралын хэв маяг”
сургалт



Зураг 24. “Байгууллагын соёл ба хандлага”
сургалт

Байгууллагын нийт албан хаагчдыг хоёр жил тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төлөвлөсний дагуу “Монос эрүүл мэндийн өдөрлөг” нээлттэй арга хэмжээг 2023 оны 12 дугаар сард байгууллагадаа төлөвлөн авч, эрүүл мэндийн 8 үзүүлэлтээр нийт 62 албан хаагч хамрагдсан.



Зураг 25. Албан хаагчид үзлэг шинэжилгээнд хамрагдаж байна.

3.3. Архив, албан хэрэг хөтлөлт

Байгууллагын архивын баримт бичгийг зохих хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хөтлөн явуулж, эмх цэгцийг хангулан ажиллаж байна. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд хөтлөгдсөн 54 хэргийн нийт 395 цаасан болон цахим хадгаламжийн нэгжийн баримт бичгийн бүрдэл, стандартыг шалгаж хуваарийн дагуу хүлээн авсан. Үүнд:

- Цаасан суурьтай 355 боть
- Цахим 40 ширхэг


Хэлтсүүдэд үүссэн баримт бичгүүдийг архивд хүлээн авахтай холбогдуулан архивын сан хөмрөг, нөхөн бүрдүүлэлт хийх, хэрэг бүрдүүлэх, баримтыг үдэж хавтаслах, техник боловсруулалт хийх арга зүй, зөвлөмжөөр ханган, цаасан баримтын бүрдэл, стандартыг шалгаж, стандарт журмыг хангасан хадгаламжийн нэгж үүсгэсэн.



Зураг 26. Архивын баримтуудыг хүлээн авч байна.

2023 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад хэлтсүүдээс санал авч нэгтгэн “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын төсөл боловсруулж, нийслэлийн Архивын газрын албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчаар хянуулан, байгууллагын дэргэдэх “Баримт нягтлан шалгах комисс”-ын 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулав.


Газрын даргын 2022 оны А тушаал 57, Б тушаал 65-ыг ARCHIVE EDOC системд шивж оруулан, нягтлан шалгальт хийж, нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунцацраалаар хянуулж, Төрийн архивын санд хугацаанд нь актаар хүлээлгэн өгсөн.



2022 онд үүссэн цахим болон захирамжлалын цахим баримтын хадгаламжийн нэгжийн бүртгэлүүдийг боловсруулж байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын хэлэлцүүлэн батлуулав.

Архивын баримтыг төрөл зүйл, он цагийн дарааллаар шүүгээнд байрлуулж байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, стандартын дагуу хадгалж, дотоодод үүссэн цахим баримтын нөөц хувь үүсгэн хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

3.4. Албан бичиг, өргөдөл, гомдолын шийдвэрлэлт



2023 оны жилийн эцсийн байдлаар буюу 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 3576 албан бичиг ирж, үүнээс хугацаанд нь шийдвэрлэсэн 3559, судлагдаж буй 17 албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 99,5%-тай байна.

Байгууллагаас гадагш нийт 1690 албан бичиг явуулав.

Иргэдээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад ирүүлсэн өргөдөл, гомдлыг цахим системд /ERP, Edoc/ болон цаасаар, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв, Засгийн газрын 11-11, 1800-1200 зэрэг газруудаас иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлыг Нийслэлийн Засаг Даргын 2022 оны А/1049 дүгээр журмаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өдөрт нь багтаан хүлээн авч, бүрдлийг шалгаж удирдлагад танилцуулан хариуцах хэлтэст шилжүүлэн, чиг үүрэгт хамааралгүй өргөдөл, гомдол, хүсэлтийг харьяа байгууллагад буцаан шилжүүлэн ажиллаж байна.

Иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлын төрөл, шийдвэрлэлтийн байдал, гарсан зөрчил зэрэг дэлгэрэнгүй мэдээ, тайланг Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоног, сар, улирал, хагас жилээр тус тус хугацаанд нь хүргүүлсэн.

2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагад нийт 2046 өргөдөл, гомдол ирүүлснээс хугацаандаа шийдвэрлэсэн 1942, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 22, судалж байгаа 22 өргөдөл, гомдол байгаа ба шийдвэрлэлтийн дундаж хугацаа 18 хоног 13 цаг, 0 минут байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлж буй гомдлын дийлэнх хувийг барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авах улсын комисс ажиллахаас өмнө буюу гүйцэтгэгч, захиалагч талтай холбоотой тухайн барилга, орон сууцыг барьж буй аж ахуйн нэгж байгууллагын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй барилгын чанар, аюулгүй байдал, стандарт, норм, дүрмийн талаарх гомдол эзэлж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийг сайжруулах үүднээс дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:


- Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийн шилжүүлж буй өргөдөл, гомдлыг байгууллагын чиг үүргийг тодорхойлж, харьяаллын дагуу шилжүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвтэй хамтран 3 удаагийн уулзалт зохион байгуулж, албан хаагчдад

мэдээлэл өгч, өргөдөл гомдлын хуваарилалтыг оновчтой болгох, шийдвэрлэлтийг сайжруулах талаар санал зөвлөмж өгч ажилласан.

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хянал тавьж, зөрчил гаргасан 6 албан хаагчид хөдөлмөрийн дотоод журмын дагуу сануулах шар хуудас олгосон.
- Байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд чиглэлийн бус өргөдөл, гомдол, хүсэлт их шилжүүлдгээс үүдэн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01/488 дугаарт албан бичгээр санал хүргүүлэв

3.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 8 ажил үйлчилгээ худалдан авахаар боловсруулж, газрын даргаар 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр батлуулсан. Төлөвлөгөөг Монгол Улсын Сангийн яамаар хянуулан Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд нийтэлсэн. Газрын хэмжээнд зохион байгуулсан зөвлөх үйлчилгээний 4 худалдан авах ажлын эрхийг баталгаажуулан цахим системд хяналт тавьж ажилласан.



Зураг 27. Худалдан авах ажиллагааны цахим систем

3.6. Шүүх хяналтын байгууллагад төлөөлөл хэрэгжүүлж ажилласан талаар

2020 оноос эхлэн хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцож Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж ирсэн.

2023 онд хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Нийслэлийн Засаг даргыг итгэмжлэлээр 1, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 14, нийт 17 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох албан хаагчид хууль тогтоомжийн дагуу шүүх хуралд оролцсон.


3.7. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Байгууллагын хэмжээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг буртгэх, хүлээн авах, хянах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчдад заавар зөвлөмж өгч, хөрөнгө орлогын мэдүүлгийг нийт 67 албан хаагчдаас хүлээн авч баталгаажуулан тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/130 дугаарын албан бичгээр хүргүүлсэн.

Шинээр нийтийн албан тушаалд томилогодооор нэр дэвшсэн нийт 30 албан хаагчаас хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг хүлээн авч хянаж баталгаажуулан холбогдох материалыг бүрдүүлэн хянуулахаар хүргүүлэн ажиллав.

Байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

1. Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн шторк, зурагт хуудас, нөлөөллийн аяны мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр дамжуулан сурталчлан ажиллалаа.



Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх таван ажиллагааг хэрэгжүүлж “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд авлигын эсрэг “НЭГДҮЕ” үндэсний хэмжээний нөлөөллийн 1 сарын аянд нэгдэн байгууллагын веб сайт болон цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн.

Зураг 28. Авлигын эсрэг нэгдье зурагт хуудас



Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, Соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комисsar Д.Золжаргал, С.Баярцэцэгтэй хамтран нутгийн захиргааны төв цогцолборт үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид болон иргэд нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн фото зургийн бүтээлийг 2023 оны 02 дугаар сарын 27-ноос 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хооронд байршуулсан сурталчлан ажиллав.

Зураг 29. Фото зураг байршуулсан байдал



1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргах үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Авлигатай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалтад нийт 14 албан хаагчдыг хамруулав.

-Нийслэлийн Иргэний танхимд 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан газрын мэдээллийн цаг арга хэмжээнд газрын нийт албан хаагчдад Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг танилцуулан зөвлөмж мэдээлэл өгч ажиллав.



ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор байгууллагын веб сайт <https://standard.ub.gov.mn> болон нийгэм олон нийтийн сүлжээ <https://www.facebook.com/urbanstandart> хуудсаар цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршууллаа.

Байгууллагын веб сайтад байршуулсан мэдээллийн агуулгыг дараах байдлаар тоймлов.

№	Мэдээлэл	Байршуулсан тоо
1.	Батлагдсан хотын стандартын мэдээлэл	52
2.	Судлагдаж буй стандартын төсөлд санал авсан	22
3.	Сэтгэл ханамжийн судалгаа	1
4.	Цаг үеийн мэдээлэл	55
5.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуваарь	45
6.	Барилга байгууламжийн их засвар шинэчлэлт, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын хуваарь	33
7.	Зарлагдсан сул орон тооны мэдээлэл	6
8.	Газрын даргын тушаал	75
9.	Санхүүгийн тайлан	4
10.	Хүний нөөцийн хөгжлийн тайлан	1
11.	Албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн мэдээлэл	2
12.	Тендерийн урилга	3
13.	Журмын төслийн санал	1
14.	Цахим сэтгүүл, гарын авлага	2
15.	Орон зайн мэдээллийн веб сан	1
16.	Барилгын төлөв байдлын дүгнэлт хүсэх тухай мэдээлэл	1
17.	Өргөх байгууламжийн бүртгэл, ашиглах зөвшөөрлийн тухай мэдээлэл	1



4.1. Хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа

Байгууллагын 2023 оны “Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө”-г газрын даргаар батлуулж, нийт 7 телевиз (МОНЦАМЭ, МҮОНТВ-Монголын мэдээ), 1 радио, 3 сонин, 8 мэдээний сайттай хамтран ажилласан. Байгууллагын үйл ажиллагааны талаар хэвлэлийн мэдээ, нийтлэл бэлтгэн телевизэд-18, радиод-3, сонинд-2, сайтуудад-3, “Нийслэлийн мэдээ” www.ulaanbaatar.mn-нд 55 мэдээллийг тус тус нийтэлсэн байна.

Мөн иргэд, олон нийтэд хотын стандартын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах, газрын үйл ажиллагааг ил тод хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд томоохон 5 удаагийн ярилцлага, 30 удаагийн яриа ёгч нийт 308 удаагийн давтамжтайгаар олон нийтэд хүргэн цацагдсан байна.



4.2. Хүний нөөцийн ил тод байдал

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хүний нөөцийн ил тод байдалд хамаарах мэдээллүүдийг байгууллагын цахим хуудас <https://standard.ub.gov.mn/>-д тухай бүр байршуулсан.

Үүнд: “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2023 оны хөтөлбөр”, хөтөлбөрийн биелэлт, байгууллагын бүтэц орон тоо, танилцуулга, бүтцийн схем, зарлагдсан сул орон тоо, сонгон шалгаруулалтын захиалга, батлагдсан албан тушаалын тодорхойлолт, албан хаагчдын утасны жагсаалт зэрэг дэлгэрэнгүй 11 төрлийн дата мэдээллийг байршуулж байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулсан.



4.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн баталгаажуулж, Шилэн дансны тухай хуулийн хүрээнд санхүүгийн ил тод байдлыг хангаж холбогдох 68 мэдээллийг <https://shilendans.gov.mn/> цахим системд сар бүр тогтмол нийтэлж мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангулсан.

ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Холбогдох чиг үүргийн дагуу Нутгийн захирагааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээ

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн холбооноос санаачлан Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоотой, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны гишүүдтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх “Асуудал шийдэл” хэлэлцүүлэгт 2023 оны 05 дугаар сарын 05-нд оролцсон. Энэ хүрээнд иргэдийн амьдрах, ажиллах, зорчих ая тухтай орчныг бүрдүүлэхээр батлан хэрэгжүүлж буй Хотын стандарт, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд стандартын баримт бичигт хэрхэн туссан талаар мэдээлэл өгч ажиллав.

2. Барилга, хот байгуулалтын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран “Өргөх байгууламжийн чанар, аюулгүй байдал, стандарт-2023” сэдэвт зөвлөгөөнийг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч 76 аж ахуйн нэгжийн 126 төлөөлөл оролцсон.



3. Нийслэлийн засаг даргын 2023 оны Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим зарим арга хэмжээний тухай А/242 дугаар захирамж, батлагдсан хотын стандартыг сурталчлан таниулах ажлын хүрээнд UCS 1502C:2023 “Цахилгаан шатад тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг танилцуулах сургалтыг Баянгол дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, лифт эзэмшигч, ашиглагч 50 гаруй СӨХ-дын 80 орчим хүн хамрагдav.



4. Баянзүрх дүүргийн Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэстэй хамтран Нийслэлийн ерөнхий боловсролын "Уудам Монгол Эдүкейшн" сургуульд хог хаягдлын менежмент хотын стандартыг нэвтрүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган хамтран ажиллаж байна.

Нийслэлийн Ерөнхий боловсролын Уудам Монгол сургуультай хамтран UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандартыг нэвтрүүлэх өдөрлөгийг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт тус сургуулийн 1-ээс 4 дүгээр ангийн сурагчид хамрагдаж, хог хэрхэн үүсдэг болон түүнийг зөв ангилан ялгах талаар сургалт зохион байгуулав. Сургалтын төгсгөлд хог хаягдлын овор хэмжээг багасгах, дахин ашиглах боломжтой хаягдлыг хэрхэн зөв ангилан хаях талаар мэдлэг бататгах дадлага хийв.



Зураг 30. Өдөрлөгийн үеэр /2023.10.17/

Мөн Уудам Монгол сургуулийн багш, ажилчдад зориулсан "Хог хаягдлын менежмент" хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж нийт 36 албан хаагч хамрагдав.

5.2. Байгууллагын дотоод хяналт, шалгалт хийсэн тухай мэдээлэл

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журам", байгууллагын ёс зүйн дотоод дүрэм, хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хэлтсүүдийн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, цаг үеийн ажлын чанар, гүйцэтгэл, хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор дотоод хяналт шалгалтыг хагас жил тутам зохион байгуулсан.

Газрын даргын 2023 оны "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/24, А/52 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж, батлагдсан удирдамж хуваарийн дагуу 7 чиглэл, 19 шалгуур үзүүлэлтээр зохион байгуулж, шалгалтын үр дүнг газрын удирдлагын Зөвлөлийн хуралд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, ажил сайжруулах санал зөвлөмжийг боловсруулан хэлтсүүдэд хүргүүлсэн



Зураг 31. Дотоод хяналт шалгалт /2023 оны 5-р сар/



Зураг 32. Дотоод хяналтын хурал /2023 оны 10-р сар/

5.3. Бусад цаг үеийн шинжтэй олон нийтийн ажлын талаар

Газрын даргын 2023 оны А/09 дүгээр тушаалаар “Биеийн тамир, спорт хамтлаг”, А/10 дугаар тушаалаар “Эцэг эхийн зөвлөл,” А/11 дүгээр тушаалаар “Залуучуудын зөвлөл”-үүдийг шинэчлэн байгуулсан. Тус зөвлөл, хамтлагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, зөвлөлөөс зохион байгуулж буй арга хэмжээнд албан хаагчдыг бүрэн хамруулсан. Байгууллагын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй хамруулах, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чийрэгжүүлэх хүрээнд спорт, урлагийн дараах арга хэмжээг зохион байгуулав.

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/94 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан Цасны баяр, өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд байгууллагаараа оролцов.



2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Мэтгэлцээний тэмцээн 2023 оны 04 дүгээр сарын 1-ний өдөр зохион байгуулгажд тус газрын 3 албан хаагч оролцож, багаараа “Тэргүүн байр” эзлэн амжилттай оролцлоо.



3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Экологийн цагдаагийн албанаас 04 дүгээр сарын 22-ны өдөр буюу “Эх дэлхийн өдөр”-ийг “Хүн бүр байгаль хамгаалагч” аяны хүрээнд зохион байгуулсан. Уг өдөрлөгийн арга хэмжээг дэмжин Хотын стандарт, хяналтын газрын хамт олон идэвхтэй оролцсон.




4. Хотын стандарт, хяналтын газрын албан хаагчдын дунд Спортын 5 төрөлт анхдугаар тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Тэмцээн шатар, ширээний тенис, дартс, гар бөмбөг, сагсан бөмбөг гэсэн төрлүүдээр зохион байгуулагдаж, багын нийлбэр дунгээр “Хатуу самар” баг тэргүүн байр эзэлж Шилжин явах цомын эзэн боллоо.



5. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-иргэдийн оролцоо” хавар, намрын мод тарих арчлах арга хэмжээнд нэгдэж 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Сонгинохайрхан дүүрэг, Баруун салаа, “Бумбатын булаг”-т, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Баянзүрх дүүргийн “IGM” цэцэрлэгт хүрээлэнд мод тарих, арчлах, цэнэг усалгаа хийх, нөхөн сэргээлт хийх ўйл ажиллагааг хэрэгжүүлэн идэвхтэй оролцсон.



6. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар Марафон-2023” олон улсын гүйлтийн тэмцээнд тус газрын албан хаагчид 5 км эрүүл мэндийн гүйлтийн төрөлд амжилттай оролцсон.



7. Стандарт хэмжил зүйн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Иргэдэд ээлтэй стандарт” өдөрлөг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан. Өдөрлөгийн үеэр иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хотын стандартын тухай мэдлэг ойлголт өгч, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж ажиллав.



8. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны аварга шалгаруулах спортын V дугаар наадмын нэгдсэн удирдамжийн дагуу тус Хотын стандарт, хяналтын газраас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дундах 4 дүгээр бүсийн тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав.

Тэмцээн Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо Алдар спорт хорооны зааланд эрэгтэй, эмэгтэй сагсан бөмбөг, Волейбол, Дартс, Ажлын байрны дасгал гэх спортын 4 төрлөөр 10 байгууллагын нийт 200 албан хаагчид, мэргэжлийн дасгалжуулагч, шүүгч нар оролцсон.



Зураг 33. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа

Багийн нийт дүнгээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар-/НХААГ/-“Шилжин явах цом”-ын эзэн боллоо.



Тус байгууллагын албан хаагчид Сагсан бөмбөгийн төрөл /эрэгтэй/-д Дэд байр, Гар бөмбөгийн төрөл /эмэгтэй/-д эмэгтэй Дэд байр, тус тус мөнгөн медаль хүртэж амжилттай оролцлоо.



9. Монгол улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагсаны түүхт 384 жилийн ойг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын дунд Улаанбаатар хотын өмнө тулгамдаж буй асуудал, шийдлийг хэлэлцэх, харилцан туршлага солилцох зорилгоор газрын даргын 2023 оны “Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах тухай” А/47 дугаартай тушаал батлагдсан.

Эрдэм шинжилгээний бага хурлыг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөл зохион байгуулж, хэлтэс бүрийн төлөөлөл 8 албан хаагч бүртгүүлж илтгэл хэлэлцүүллээ.



Шүүгчдийн бүрэлдэхүүнд ХСХГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Э.Даваахатан, Амар Трейнинг ХХК-ны захирал, Монголын Мэтгэлцээний Нэгдсэн Танхимын Дэд тэргүүн Ч.Сайханаа, МУИС Шинжлэх Ухааны Сургуулийн Газарзүйн тэнхимиийн багш, дэд профессор Б.Сайнбаян нар урилгаар ажилласан.



Шүүгчдийн нийлбэр дүнгээр:

1-р байранд БСАБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Н.Чимэдрэгзэн “Лифтний насжилт, ашиглалтын төлөв байдлын судалгаа” сэдвээр,

2-р байранд ХХСХ-ийн Тогтвортой хотын стандарт хариуцсан мэргэжилтэн М.Амарзаяа “Хотын геометр шинж төрх болон бичил уур амьсгалын харилцан хамаарлыг SVF-ын аргачлалаар тодорхойлох нь” сэдвээр,

3-р байранд ЗСХ-ийн Цахим хөгжүүлэлт хариуцсан ажилтан Б.Батболд “Газарзүйн мэдээллийн системд сууринсан олон шалгуурт шинжилгээний аргаар үерийн эрсдэлийг тодорхойлох нь” сэдвээр тус тус шилдгээр шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулж, оролцсон нийт албан хаагчдад Батламж гардууллаа



ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Хотын стандарт, хяналтын газар нь шинэчлэн батлагдсан бүтэц, орон тоо, дурмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхлүүлсэн нь газрын үйл ажиллагааг шинэ дүрэм, чиг үүрэгт нийцүүлэн үйл ажиллагааг жигдрюүлэхэд тодорхой хугацаа шаардсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар барилга, дэд бүтцийн чиглэлээр төрийн хянал шалгалтын 11 хяналтын чиг үүрэг шилжин ирж, холбогдох 5 яаманд улсын (ахлах) байцаагчийн эрх олгуулах тухай хүсэлтийг шийдвэрлүүлэн, төрийн хяналт шалгалтыг хэвийн зохион байгуулан ажиллаж байна.

Барилга дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд барилга, дэд бүтцийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулахаар тусгуулж батлууллаа.

Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд нийт 15 бүлэг 52 хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулаад байна. Цаашлаад хотын

стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үндсэн цогц харилцааг зохицуулсан журмын төсөл, дараагийн ээлжийн хотын стандартуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах томоохон ажлыг зохион байгуулах юм.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр:

- “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ыг НИТХ-аар батлуулж, Хотын стандартыг хянан хэлэлцэх үүрэг бүхий зөвлөлийг байгуулах;
- “Хотын стандартын тогтолцоог 2024-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулж батлуулах;
- III ээлжийн 7 бүлгийн 24 хотын стандартыг НИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах;
- Хотын стандартыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх;
- Стандарт, норм дүрмийг мөрдүүлэхэд хэрэгжүүлэх механизмыг сайжруулах;
- Тогтвортой хотын олон улсын стандартыг нэвтрүүлэх.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах чиглэлээр:

- Хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, “Барилга ашиглалтад оруулах” үйл ажиллагааг төлбөртэй үйлчилгээ болгох, барилга ашиглалтад оруулах дүгнэлтийг үнэт цаасаар хэвлэх;
- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгавар болон биелэлтийн баримт нотолгоо бүхий мэдээллийн ил тод байдлыг хангуйлж, нэгдсэн цахим системд шилжүүлэх;
- Бүтээн байгуулалт, тохижилтын зураг төслийг зөвшилцөх;
- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажилд захиалагчийн хяналтын эрх, үүргийг мэргэжлийн зөвлөх үйлчилгээ бүхий ААНБ-уудад шилжүүлэх;
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын журмыг батлуулах;

Барилга, дэд бүтцийн чиглэлээр хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэх чиглэлээр:

- Хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Барилгын зориулалттай газар олгох, барилга төлөвлөх, барьж байгуулах, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах бүхий л үе шатны ажлын мэдээллийн ил тод байдлыг хангуйлж, нэгдсэн цахим системд шилжүүлэх;
- Хяналт шалгалтын [/www.shilenkhyanalt.gov.mn/](http://www.shilenkhyanalt.gov.mn/) цахим системийг яаралтай сэргээн ажиллуулах цаашид шинэчлэл хийх;
- Хяналт шалгалтын давхардлыг арилгах зорилгоор Хяналт шалгалт хийх нийтлэг журамд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах /хамтарсан шалгалтын удирдамж батлах, бланкны загвар г.м./
- Барилга байгууламж, шугам сүлжээний нэгдсэн мэдээллийн сан, хяналтын цахим системийг бий болгох.